

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2023/01/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2023 он

Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Аудитор: Х.Еркегүл

Утас: 99040705

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.04 № 334  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Галшар сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 375,708.8 мянган төгрөг, авлага 113,785.0 мянган төгрөг, бараа материал 114,381.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,566,215.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 4,175,085.9 мянган төгрөг байна.

Тайлант онд 291,453.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 579,678.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, төсвийн байгууллагуудад 936,264.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Оны эцэст төсөвт байгууллагуудын зарцуулагдаагүй үлдэгдэл 118,632.0 мянган төгрөгийг сумын ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 26,886.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 22,098.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 4,264.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Галшар сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 20,075.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг 118,865.4 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн зэрэг алдаа, зөрчил илэрлээ.



232330455

байгууллагуудын санхүүгийн тайланг 118,865.4 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн зэрэг алдаа, зөрчил илэрлээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төлөөр бүрэн биелүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хамт бэлтгэх шаардлагатай байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		909,852.9	608,870.9
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	319,963.2	375,708.8
32	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	4а, 4б	0.0	0.0
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	274,499.6	113,785.5
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	0.0	0.0
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	309,140.1	114,381.7
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	6,250.0	4,995.0
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	0.0	0.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		5,630,590.8	3,566,215.0
37	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	11а, 11б	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж		0.0	0.0
37200	Үнэт цаас		0.0	0.0
37300	Урт хугацаат зээл		0.0	0.0
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	5,630,590.8	3,566,215.0
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		5,545,319.1	3,518,906.4
39300	Биет бус хөрөнгө	13	85,271.8	47,308.5
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>6,540,443.8</b>	<b>4,175,085.9</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		9,802.4	0.0
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	9,802.4	0.0
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	9,802.4	0.0
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	0.0
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	0.0	0.0
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>6,530,641.4</b>	<b>4,175,085.9</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		6,530,641.4	4,175,085.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,580,710.0	415,237.0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		0.0	0.0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		0.0	415,237.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	0.0
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		4,408,814.9	3,717,214.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		541,116.4	42,634.3
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0.0	0.0
51600	Нөөцийн сан		0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо		0.0	0.0
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>6,540,443.8</b>	<b>4,175,085.9</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		3,728,999.9	1,553,830.0
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		115,156.9	255,964.5
110	Орлогын албан татвар		44,784.2	131,688.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		44,784.2	131,688.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		42,223.3	64,103.7
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		28,149.4	60,172.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	832,073.8	507,076.5
120	Нийтлэг татварын бус орлого		832,018.8	507,076.5
121	Хөрөнгийн орлого		0.0	0.0
122	Тусламжийн орлого		55.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		0.0	0.0
124	Зээлийн орлого		0.0	0.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		2,781,769.2	790,789.1
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	2,232,479.1	997,961.6
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		2,232,479.1	997,961.6
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		2,110,817.7	952,080.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,166,383.6	342,025.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		151,648.4	42,828.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		161,595.9	202,863.0
2104	Хангамж, бараа материалын зардал		90,200.2	36,207.3
2105	Нормативт зардал		122,829.8	408.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		32,926.6	17,205.0
2107	Томилолт, зочны зардал		13,262.7	13,247.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		34,825.7	42,915.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		337,144.8	254,380.3
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		121,661.4	45,881.2
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		0.0	0.0
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		1,496,520.8	555,868.5
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		9,081.5	0.0
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		652,706.8	2,646,235.9
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		852,895.5	-2,090,367.4

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,684,246.8</b>	<b>0.0</b>	<b>5,684,246.8</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-6,500.9	0.0	-6,500.9
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,677,745.9</b>	<b>0.0</b>	<b>5,677,745.9</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>852,895.5</b>	<b>0.0</b>	<b>852,895.5</b>
10	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,530,641.4</b>	<b>0.0</b>	<b>6,530,641.4</b>
11	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>6,530,641.4</b>	<b>0.0</b>	<b>6,530,641.4</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-265,188.1	0.0	-265,188.1
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>6,265,453.3</b>	<b>0.0</b>	<b>6,265,453.3</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-2,090,367.4	0.0	-2,090,367.4
20	<b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>4,175,085.9</b>	<b>0.0</b>	<b>4,175,085.9</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,869,496.0	1,181,098.7
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	115,156.9	255,964.5
110	Орлогын албан татвар	44,784.2	131,688.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	44,784.2	131,688.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	42,223.3	64,103.7
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,149.4	60,172.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,877.8	13,605.2
1181	Газрын төлбөр	1,183.3	13,414.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	11,088.3	33,151.9
1183	Бусад татвар	0.0	0.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	86,768.2	134,345.1
120	Нийтлэг татварын бус орлого	86,768.2	134,345.1
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,667,570.8	790,789.1
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,991,617.8	847,737.0
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,991,617.8	847,737.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,867,581.4	750,158.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,163,617.0	341,708.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,330.0	43,145.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	159,499.9	202,863.0
2104	Хангамж, бараа материалын зардал	67,742.5	32,712.1
2105	Нормативт зардал	118,500.9	615.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,127.8	29,271.8
2107	Томилолт, зочны зардал	13,124.7	13,197.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,250.5	45,086.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,388.1	41,558.6
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,036.3	97,578.9
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	877,878.2	333,361.7
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	0.0	0.0
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	764,464.7	277,616.2
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	764,464.7	277,616.2
2200	Дотоод эх үүсвэрээр	764,464.7	277,616.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-764,464.7	-277,616.2
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	0.0	0.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	113,413.5	55,745.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	206,549.7	319,963.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	319,963.2	375,708.8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,443,478.00</b>	<b>1,048,111.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>906,404.70</b>	<b>773,690.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>863,354.30</b>	<b>730,674.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>372,790.40</b>	<b>341,708.32</b>
210101	Үндсэн цалин	219,608.30	236,951.64
210102	Нэмэгдэл	74,797.40	46,477.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,960.00	2,345.00
210104	Урамшуулал	15,063.60	15,204.39
210105	Гэрээт ажлын хөлс	59,361.10	40,729.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,600.30</b>	<b>43,145.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,688.20	30,951.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,728.00	3,130.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,982.80	2,437.84
210204	Ажилгүйдлийн даатгал	745.30	616.19
210205	Эрүүл мэндийн даатгал	7,456.00	6,009.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>286,579.60</b>	<b>202,863.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	37,684.40	22,044.10
210302	Түлш, халаалт	247,575.20	180,818.92
210303	Цэвэр, бохир ус	1,320.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,652.30</b>	<b>26,644.51</b>
210401	Бичиг хэрэг	3,264.70	4,957.50
210402	Тээвэр, шатахуун	18,368.20	17,576.41
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,081.30	2,172.00
210404	Ном, хэвлэл	250.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,688.10	1,938.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>615.30</b>	<b>615.30</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	615.30	615.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>30,467.50</b>	<b>30,466.77</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000.00	4,999.98
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100.00	100.00
210604	Урсгал засвар	25,367.50	25,366.79
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,392.20</b>	<b>13,197.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,392.20	13,197.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,539.90</b>	<b>39,884.34</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,122.70	37,683.52
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	856.60	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	511.90	328.73
210804	Тээврийн хэрэгслийн татвар	261.00	245.83
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	89.50	74.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	366.60	366.60
210807	Газрын төлбөр	1,331.60	1,185.07
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,716.80</b>	<b>32,150.04</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,927.30	28,427.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,789.50	3,722.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,050.40</b>	<b>43,015.83</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,050.40</b>	<b>43,015.83</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,888.20	38,888.12
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,162.20	4,127.71
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>353,073.30</b>	<b>274,421.16</b>
223001	Бусад хөрөнгө	353,073.30	274,421.16
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>184,000.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	184,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,443,478.00</b>	<b>1,050,479.84</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,144,365.60</b>	<b>999,199.56</b>
320001	Орон нутгийн төсвөөс	962,798.30	817,632.26
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	181,567.30	181,567.30
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>299,112.40</b>	<b>51,280.28</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	50,780.28
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.00	500.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	248,112.40	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	248,245.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	250,613.96

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,913.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	26,913.45
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	22,098.57
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,067.57
210401	Бичиг хэрэг	534.67
210402	Тээвэр, шатахуун	5,122.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	230.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,202.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,202.40
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,828.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,184.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	644.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,814.88
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,264.88
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,264.88
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	26,886.78
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,886.78
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,886.40
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,000.38
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(26.67)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26.67

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 3.1 Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Галшар сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 118,865.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг санхүүгийн тайланд залруулж, 20,075.5 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлээ.

##### 3.1.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга:

- Соёлын төв: Хаалтын тайлан хийхэд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 77.0 мянган төгрөгийг улсын төсөвт шилжүүлээгүй;
- ЖДБДС: Хаалтын тайлан хийхэд 118,762.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө болон авлагыг өмнөх оны үр дүн дансанд хааж бүртгээгүй орлого үр дүнгийн тайланд зардлаар бүртгэсэн;
- ЭМТ: Төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 26.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;

##### 3.1.2 Албан шаардлага:

- Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил давтагдаж төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөөг 20,075.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлж аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 3.2 Галшар сумын харьяа улсын болон орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын дүн, илэрсэн алдаа зөрчил.

Галшар сумын засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн байгууллага 2, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 1, төрийн сан 1, орон нутгийн тусгай сан 4, улсын төсвийн байгууллага 4, нийт 12 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Үүнээс 6 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган, 3 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж аудитад хамруулсан. ЖДБДС, ЭЭС болон улсын төсөвт шилжиж буй ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ-ийн хаалтын балансыг Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хүрээнд шалгасан болно.

ЗДТГ-ын санхүүгийн тайланд Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Өндөрхаан итгэл аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Галшар сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 205,436.9 мянган төгрөгийн 7 алдаа, 61,813.1 мянган төгрөгийн 8 зөрчил, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд шилэн дансны тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 454,700.8 мянган төгрөгийн 3 зөрчил, нийт 721,950.8 мянган төгрөгийн 18 алдаа зөрчил илэрсэн байна.

Үүнээс 205,436.9 мянган төгрөгийн 7 алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, 136,698.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгч, 1,196.6 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 378.619.3 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Алдаа зөрчлийг байгууллагаар нь авч үзвэл:

##### **Засаг даргын тамгын газар:**

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл дансны эхний үлдэгдлийг 41,900.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

- Засаг даргын нөөц сан, эрсдэлийн сан, нэг удаагийн шагнал урамшуулал, хур хог хаягдлын зардлаас захирамж, тушаал шийдвэр гаргаж 16,058.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулсан боловч шийдвэрийн хэрэгжилт, хийсэн ажлын гүйцэтгэлийн тайлан зэрэг анхан шатны зарцуулалтын баримтын бүрдэл хангалтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Эрсдэлийн сангаас 1,798.2 мянган төгрөгийн шатахууны төлбөр шилжүүлсэн боловч зарцуулалтын анхан шатны баримт байхгүй. Мөнгөн хөрөнгө захиран зарцуулах тухай ЗДТГ-ын даргын тушаал гаргаж зарцуулсан нь Гамшгийн тухай хуулийн 32.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 32.1.3-д "гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах" гэж заасныг зөрчсөн нь Төрийн албаны тухай хуулийн 39.1.3-д "хуульд нийцээгүй шийдвэр гаргах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 231,125.1 мянган төгрөгийн 8 орлогын гүйлгээ, 79,517.3 мянган төгрөгийн 6 зарлагын гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### ***Иргэдийн төлөөлөгчдийн хурал:***

- Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй, нэмэлт дансны 3,824.3 мянган төгрөгийн гүйлгээг тохируулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

#### ***Эрүүл мэндийн төв:***

- Үнэ төлбөргүй авсан 629.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогод бүртгээгүй орхигдуулсан.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

- Тайлант онд нэр бүхий албан хаагчдад ээлжийн амралтын цалинг 1,069.7 мянган төгрөгөөр илүү олгосон. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл дэх "Ээлжийн амралт түүний хугацаа, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/191 дүгээр тушаалаар ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Жилийн эцэст 2,428.4 мянган төгрөгийн эмийн зардлыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн ба “*Үнэн зөв байдал*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 28,155.1 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

#### **Ерөнхий боловсролын сургууль:**

- Хичээл ороогүй үед нэг өдрийн 126.9 мянган төгрөгийн хүнсний материалын зарлага гаргасан. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 450 тоот тогтоол “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардал 3475 (гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### **Хүүхдийн цэцэрлэг:**

- Эрхлэгчийн шийдвэргүйгээр 12 хүнд 1138 цагийн 9,035.7 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйл “Илүү цагаар ажиллуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.4-д “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно”, 3.3-д “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 3,141.0 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

#### **Соёлын төв:**

- Санхүүгийн программ худалдан авах гэрээний дагуу Хас эрин орчил ХХК-д 1,500.0 мянган төгрөгийг шилжүүлэн урьдчилгаа дансаар бүртгээгүй, санхүүгийн тайланд улсын төсвөөс олгосон 88,339.8 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг үнэн зөв

ангилж илэрхийлээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг 14,211.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн зэрэг нийт 159,082.8 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг 65.4 хувьтай мэдээлсэн байна. Үүнд таван сая төгрөгөөс дээш орлогын 92,261.9 мянган төгрөгийн 10 гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой 398,0 мянган төгрөгийн 12 тушаал шийдвэрийг мэдээлж, таван сая төгрөгөөс дээш 50,370.3 мянган төгрөгийн 7 орлогын, 55031.6 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээг мэдээлээгүй зэрэг нийт 105,401.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	118,865.4			1	118,865.4	1	118,865.4				
ИТХ	1	3,824.3	-	-	1	3,824.3	1	3,824.3				
ЗДТГ	1	41,900.0			1	41,900.0	1	41,900.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>164,589.7</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>3</b>	<b>164,589.7</b>	<b>3</b>	<b>164,589.7</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	20,075.5			1	20,075.5						
ИТХ	-	-	-	-	-	-	-	-				
ЗДТГ	2	17,856.3			2	17,856.3						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>37,931.8</b>			<b>3</b>	<b>37,931.8</b>						

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ЗДТГ	1	328,498.7					1	328,498.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>328,498.7</b>					<b>1</b>	<b>328,498.7</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	6			5	1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ОНТС	4		4					
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
6	ААНТҮГ	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>12</b>	<b>7</b>	<b>5</b>		<b>6</b>	<b>1</b>		